

ЭРДЭС ТЭЖЭЭЛИЙН ДУТЛААС ГАРАХ АРГА ЗАМУУД: СУРГУУЛИЙН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

*Д. Оюунцэцэг
Социологийн ухааны магистр*

Удиртгал

Тус өгүүлэл нь сургуулийн насны хүүхдийг эрдэс тэжээлийн дутлаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлын хүрээнд хөндөгдөх хэд хэдэн цуврал өгүүллийн эхийг тавьж байгаагаараа онцлог юм. Энэ удаагийн өгүүлэлдээ эрдэс тэжээлийн дутал гэж юу вэ дэлхий нийтэд хэрхэн ойлгож байна вэ? Амжилттай болон амжилтгүй хэрэгжсэн хөтөлбөрүүд, эцэст нь “Сургуулийн үдийн цай” хөтөлбөр Монгол улсад хэрэгжих болсон шалтгаан зэргийг ярих болно.

21-р зууны нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл нь хүн амаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарлаа хандуулж байна. Нийгмийн эрүүл мэндийн ямар ч сурах бичгийг нээгээд харахад нийгмийн эрүүл мэндийн онол түүх, олон стратеги чиглэл, улс орнуудад хэрэгжсэн бодлого гээд ерөнхийдөө ижил төстэй мэдлэгийг олгохыг зорьдог. Харин энэхүү ойлголтыг хэдийд олгох вэ? Хэн олгох вэ яаж олгох вэ гэдэг нь харилцан адилгүй. Ж:Австрали улсад зургаан настангуудыг сургуулийн хөтөлбөрт хамруулан хамгийн түрүүнд хүүхдүүдийг дурлуулах гэж хичээдэг үйл ажиллагаа нь биеийн тамирын хичээл, дараа нь хоол тэжээлийн талаарх мэдлэг олгох өдөр бүрийн тоглоомын аргад суурилсан сургалтууд, тухайлбал ямар ногоо ямар ашигтай вэ? Юуг хүнсэндээ хэрэглэснээр өндөр болох вэ, хүчтэй болох вэ гээд энгийн юм шиг мөртлөө зайлшгүй хэрэгцээт мэдээллийг сургуулийн ширээний ард ярилцдаг, эцэг эхчүүд ч давхар суралцдаг. Харин манайд эдгээр мэдлэг мэдээлэл нь нилээд хожмоо яригддаг, хүүхдийн хоол тэжээлийн асуудлыг эцэг эхэд нь биш, төр засагт даатгасан байдалтай байна.

Өлөн зэлмүүн байдал уураг илчлэгийн дутал, түүнийг хэмжих нь

Өлөн зэлмүүн байдал, уураг илчлэгийн дутал нь бага насны хүүхдийн эрүүл мэнд, тэдний оюун санаа, бие физиологийн хөгжилд “сэргээгдэшгүй” сөрөг үр дагаврыг авчирдаг. Хоол тэжээлтэй холбоотой хүүхдэд учирч буй энэхүү сөрөг үр дагаврыг Мянганы Хөгжлийн Зорилт (MDG) анхааралдаа аван 1990-2015 он гэхэд өлсгөлөнд нэрвэгдэгсдийн харьцааг одоо байгаагаас “хоёр дахин” бууруулах зорилтыг дэвшүүлсэн байдаг (UNDP, 2008, р.6). Бага насны хүүхэд уураг илчлэг багатай хоол идэх, хагас өлсгөлөнд нэрвэгдэх энэхүү үзэгдэл нь бага, дунд орлогын түвшинтэй орнуудад ихэвчлэн тохиолдож байна. Үүнд: Төв болон Зүүн-Өмнөд Азийн улсууд мөн Африкийг нэрлэж болно. (Black et al., 2008).

Буурай хөгжилтэй оронд, сургуулийн насны сурагчид ихэвчлэн богино хугацааны өлсгөлөн, протейн-эрдсийн, уураг илчлэг багатай хоол тэжээлийн дуталд автсанаас болж алдсан энерги нөхөж чадахгүйгээр өлсгөлөнд нэрвэгддэг, цаашлаад энэ нь даамжирч зайлшгүй шаардлагатай уураг илчлэгийн дуталд орох нь элбэг байна. (Cueto & Chinen, 2008). Энэ тухай НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF) хөгжиж байгаа оронд хүүхэд тэжээллэг багатай хоол идэх, өлсгөлөнд нэрвэгдэж байгаагийн үндсэн шалтгаан нь хүрээлэн байгаа орчин, эдийн засаг, нийгэм улс төрийн хүчин зүйлс зэргийг голлох үүрэгтэй байгааг онцолсон (Black, et al., 2008). Ялангуяа уураг илчлэг багатай хоол идэх, өлөн зэлмүүн байдал гэсэн энэхүү ойлголт нь буурай хөгжилтэй, хөгжиж байгаа орнуудад “хоол тэжээлийн аюулгүй байдал алдагдах” тай салшгүй холбоотой байна. Тухайлбал, эдийн засгийн чадавхиасаа болоод хоол тэжээлийн шаардлагыг хангахуйц аюулгүй, тэжээллэг, соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц хүнсийг тэд хэрэглэж чадахгүй байгаа юм (Black, et al., 2008, р. 244).

Хүүхдэд уураг илчлэгийн дутал байгаа эсэхийг дараах гурван аргаар тодорхойлдог. Үүнд: Антрометр хэмжилт буюу биеийн өсөлтөөр, удаах арга нь биохимийн аргаар цус болон шээсэн дэх биохийн агууламжаар, нилээд нарийн тодорхойлдог арга нь клиник арга буюу хоол тэжээлийн дутагдалтай байгааг илэрхийлдэг биеийн гадаад шинж тэмдгүүдээр дамжуулан хэмжилт хийх арга.

Биохимийн болон клиник аргууд нь практикт хэрэглэхэд цаг хугацаа их зарцуулагддаг, өртөг өндөртэй, зохион байгуулахад хүндрэлтэй зэрэг шалтгаануудаас болоод практикт бага хэрэглэгддэг.

Дээрх аргуудаас Антрометрийн аргаар авсан мэдээлэл нь амьдралд өргөн хэрэглэгддэг, дараах давуу талуудыг өөртөө багтаадаг. Үүнд: А.Судлаж буй асуудалд тайлбарлал хийхдээ амьдралд ойрхон ойлгомжтой. Б.Уураг илчлэгийн дутагдалд байгаа ядуу давхаргынхны орчны болоод эрүүл мэндийн эрсдлүүд, халдварт өвчинд нэрвэгдэх байдал болон бусад хүчин зүйлсийг хэмжих альтернатив хэмжүүр болж чаддаг. В.Өвчний, үхлийн мөн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн шалтгааныг хувь хүний болоод олон нийтийн түвшинтэй холбон мэдрэгдэхүйц таамаглалыг дэвшүүлж чаддаг. Ү.Уураг илчлэгийн дуталд нөлөөлж байгаа эдийн засгийн болоод хүрээлэн буй орчны талаарх амжилтад хүрсэн, хүрээгүй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг үнэлэхэд тохиромжтой (UN2ACC/SCN,1992).

Антрометрийн хэмжилтийн дүнд уураг илчлэгийн дуталтай эсэхийг *тураалтай, өсөлт хоцролттой, туранхай* эсэх гэсэн гурван хэлбэрээр тодорхойлдог. (de Onis et al., 2007)..

Хүүхдийн хувьд насандаа тохирохгүй бага жинтэй байх нь цочмог болон архаг хэлбэрийн уураг илчлэгийн дутлыг илэрхийлдэг ба “Тураалтай” хэмээн (жинг/настай харьцуулж) тодорхойлдог. Ялангуяа хүүхэд тураалтай байна гэдэг нь урт хугацааны турш уураг илчлэгийн дутлыг харуулж байгаа бөгөөд энэ нь цаашлаад амь насанд ч эрсдэл учруулж болдог.

Харин насандаа тохирохгүй намхан байвал архаг хэлбэрийн уураг илчлэгийн дуталд орсон буюу “Өсөлт хоцролттой, навтгар” хэмээн (өндрийг нь / настай нь харьцуулж) тодорхойлдог.


Зарим хүүхэд өндөртөө тохирохгүй бага жинтэй байж болох ба энэ нь уураг илчлэгийн дутлын цочмог хэлбэрт орсныг илэрхийлж “Туранхай” хэмээн (жинг/өндөртэй харьцуулж) үздэг. Туранхай байгаа олон шалтгаануудаас шаардлагатай эрдэс тэжээлийн дутагдалтай тухайлбал төмөр, цайр, амин хүчил, витамин В-12 болон Витамин-А зэргийн дутлаас үүссэн шинж тэмдгийг онцгойлон авч үзэж, тохирсон арга хэмжээг авдаг. (Black, et al., 2008).

ДЭМБ-ын боловсруулсан хүүхдийн өсөлтийн дээрх стандартын дагуу жин/нас, өндөр/нас, жин/өндрийн харьцааны голчоос хэлбэлзэж байгаа Z оноогоор тооцдог ба дунд зэргийн

($-3CX \leq Z \leq -2CX$), хүнд зэргийн ($Z \leq -3CX$), дунд болон хүнд зэргийн ($Z \leq -2CX$) гэсэн ангиллуудад хуваан үздэг байна.

Амжилттай болон амжилтгүй үр дүн үзүүлсэн хөтөлбөрүүд

Дэлхий нийтэд өлсгөлөн, хоол тэжээлийн дуталтай хүүхдүүдийн 80 орчим хувь нь 20 орчим улсад тархсан гэж үздэг. Эдгээр улсуудад анхаарлаа хандуулан, чиглэсэн хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэхийг тухайн улс орнуудын эрүүл мэндийн бодлогоор төдийгүй Мянганы Хөгжлийн Зорилтуудад ч тусгасан байна (UN2ACC/SCN,1992).




Зураг 1: Өлөн ээлмүүн байдал ихтэй 20 улс орон. Хоол тэжээлээ хангалттай хэмжээнд авч чаддаггүй, өлсгөлөн, тураалтай 5-аас доош насны хүүхдүүдийн 80-аас дээш хувь нь эдгээр орнуудад байдаг. (Bryce et al., 2008)

Дээрх зургаас харахад хоол тэжээлийн дуталд орсон, хоол тэжээлээ хангалттай хэмжээнд авч чаддаггүй гэсэн тодотголтой 20 орноос 5 аас доош насны хүүхэд хангалттай хэмжээнд хоол тэжээлээ авч чаддаггүй өлсгөлөнгийн байдалтайгаараа Африкийн орнууд тэргүүлж байна.

Хүүхдийг хоол тэжээлээр нь дэмжин тэтгэх дэлхийн чиг хандлага өнөөдөр 24-өөс доош сартай хүүхэд болон түүний эхийг хамруулан тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэсэнтэй өндөр хөгжилтэй орнууд дуу нэгтэй хүлээн зөвшөөрөөд байна. Энэ нь мэдээж 24 сараас дээшхийг нь орхи гэж байгаа биш, харин хэдийд хэнд ямар зардал гаргавал илүү үр дүнтэй вэ гэдгийг судлаад энэхүү хариултыг өгсөн байгаа юм (Oyuntsetseg.,2011).

Дээрх 20 улс оронд хэрэгжсэн хөтөлбөрүүдээс хамгийн үр дүнтэй болсон хөтөлбөрүүдэд 6-59 сартай хүүхдүүдэд А витамин нэмэгдлээр олгох, 6-9 сартай хөхөөр хооллодог хүүхдүүдэд нэмэгдэл тэжээл олгох иоджуулсан давсыг хоолондоо хэрэглэх зэргийг нэрлэж болно (Зураг 2). Өөрөөр хэлбэл эдгээр хөтөлбөрүүд нь шалгагдсан бусад улс орнууд хэрэгжүүлж болох хөтөлбөрүүд гэж дүгнэж болох юм. Хэдийгээр дээрх улс орнуудтай харьцуулагдахуйцаар судалгаанд ороогүй ч манай улсад амжилттай хэрэгжсэн хөтөлбөрийн тоонд А витамин нэмэгдлээр олгох, иоджуулсан давс зэрэг нь зүй ёсоор ордог.



Зураг 2: Ёр заагдсан 20 улс оронд хэрэгжсэн хөтөлбөрүүдээс хамгийн амжилттай болсон хөтөлбөрүүд (Bryce et al., 2008)

Харин хамгийн үр дүн муутай, өлсгөлөн хоол тэжээлийн дутлаас гарахад ямар ч үр нөлөө үзүүлээгүй хөтөлбөрүүдийн тоонд хүүхдийн өсөлтийг хянах, 24 сараас дээшхи хүүхдэд нэмэгдэл тэжээл олгох, мөн сургуулийн насны хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр (5-аас дээш настнуудад) орсон байгаа юм (Зураг 3-аас харна уу?). Үр дүнгүй гэж үзсэн үндсэн шалтгаан нь сургуулийн хүүхдийн хоол тэжээл нь хүүхдийн өсөлт хөгжилтийг хангахад, дутагдсан эрдэс тэжээлийг нөхөхөд ямар нэг үр дүн үзүүлээгүй. Харин тухайн улс орнууд боловсролын системээ дэмжихтэй холбоотойгоор урт хугацаатай төсөл хэрэгжүүлж байгаа бол өөр асуудал юм хэмээн дүгнэсэн байна (Bryce et al., 2008).

Хөтөлбөрийн нэр	Хэрэгжсэн эсэх		Хөтөлбөр хэрэгжсэн түвшин	
	Тийм	Үгүй	Үндэсний түвшинд	Сонгосон дүүрэгт
-Өсөлтийг хянах	20	0	12	8
-Сургуулийн өмнөх насны хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр /24 сараас дээш/	10	10	3	7
-Сургуулийн насны хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөр /5 аас дээш нас/	20	0	4	16

Зураг 3 Өлсгөлөн, тэжээлийн дутлыг бууруулахад үр дүнтэй гэдэг нь нотлогдоогүй хөтөлбөрүүд (Bryce et al., 2008)

Эндээс дүгнэхэд тухайн улс орон боловсролоо дэмжихэд, хүүхдүүдээ татахад, зорилтот бүлгийн хүүхдүүд зэрэгт л энэхүү сургуулийн хоол хөтөлбөр нь үр дүнгээ өгдөг гэж үзэж болохоор байна. Ингээд улс орнуудад сургуулийн хоол тэжээлийн хөтөлбөр хэрхэн эхэлсэн ямар үүх түүхтэйг товчхон сонирхъя.

Сургуулийн хоол хөтөлбөр үүссэн түүх, өнөөгийн үзэл баримтлал

Дэлхий нийтэд сургуулийн хоол тэжээлийн хөтөлбөрүүд хэрэгжсэн түүх нь олон янз байдаг ч, анхнаасаа л ядуу буурай бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн зорилготой байсан нь өнөөг хүртэл

хадгалагдсаар байна. Германд 1790 онд Мюнхийн (Munich) санаачилгаар орон гэргүй хүүхдүүдийг сургах, түүнийхээ хажуугаар хооллох хөтөлбөрийг явуулж эхэлсэн байдаг. Түүний дараа нь 1865 онд Францад, Виктор Гюго өөрийн гэрийн ойролцоо байдаг сургуулийн ядуу хүүхдүүдэд зориулж халуун хоолыг өгч байсан байна. Харин өнөөдөр уураг илчлэгийн дуталд орсон хүүхдүүдэд шаардлагатай эрдэс тэжээлийг нөхөх үр нөлөөтэй сайн туршлага бүхий хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр амжилтад хүрэх нь хоол тэжээлийн талаарх баримтлах бодлогын салшгүй хэсэг юм (Bhutta et al., 2008). Сургуулийн хоол хөтөлбөрүүд нь сургуулийн сурагчдад илчлэгтэй хоолыг бэлтгэн өгч тэдний өсөлт, эрүүл мэндийн бусад үзүүлэлтийг дэмжихэд, цаашлаад сургуулийн сурагчдын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг байна. Иймд үр нөлөө бүхий сургуулийн хоол хөтөлбөр нь орлого багатай гэр бүлийн хүүхдүүдийн эрүүл мэндийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан байдаг.

Сургуулийн хоол хөтөлбөрийн талаарх ном зохиол судалгааны дүнд уг хөтөлбөрийн талаар үзэл баримтлалын хувьд ялгаатай хоёр тодорхой үр дүн байна. Сургуулийн хоол хөтөлбөрийг дэмжиж байгаа зарим хэсэг нь үзэхдээ хөтөлбөр нь богино хугацааны өлөн зэлмүүн байдлыг дарахад сайнаар нөлөөдөг мөн тодорхой бүлгүүдийн хүүхдийн сургуульд хамрагдалтыг сайжруулахад үр дүнтэй гэж үзсэн байдаг. Сургуулийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж дээрх үр дүнд хүрсэн улс орны тоонд Перу (Cueto & Chinen, 2008), Жамайка (Simeon, 1998), Кени (Neumann et al., 2003) мөн Хятад (Du et al., 2004) зэрэг улс орнууд санамсаргүй хяналт бүхий хэмжилт судалгааг явуулснаар дүгнэсэн байна. Үүнтэй эсрэгцэн, сургуулийн хоол хөтөлбөр үр дүнгүй гэсэн нөгөө хэсгийнхэн. Учир нь нэмэгдэл тэжээл нь сургуулийн насны хүүхдэд хэтэрхий оройтсон арга хэмжээ. Нэмэгдэл хоолны хөтөлбөр хамгийн өндөр үр нөлөөтэй байгаа нас нь хүүхэд эхийн хэвлийд буй болсноос хойш 36 сар гэдгийг олон судалгааны дүнд баталсан байдаг, төдийгүй энэхүү хугацаанд эх хүүхдийг хоол тэжээлээр дамжуулан эрүүл мэндэд нь анхаарснаар уураг тэжээлийн дутлын хэлбэр болох тураалтай, өсөлт хөгжил дутуу, туранхай хүүхдээс бүрэн сэргийлж чадна (Black, et al., 2008).

Сургуулийн хоол тэжээлийн хөтөлбөр:Монголд

Сургуулийн хоол тэжээлийн хөтөлбөр манай улсад сургуулийн бага насны хүүхдийн шаардлагатай эрдэс тэжээлийн дутлыг нөхөх мөн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2006 онд анх хэрэгжиж эхэлсэн байна. 2006 онд Ерөнхий Боловсролын Сургуульд суралцах сургуулийн насны хүүхдүүдийн түвшин 2004 онтой харьцуулахад 5.3 хувиар буурч 92.3 хувь болсон. Үүнтэй улс орны хэмжээнд сургуулийн сурагчид эрдэс тэжээлийн дуталд нилээдгүй орсныг Олон хүчин зүйлийн түүвэр судалгаагаар (MICS) сурагчдын өндөр болон жинд хэмжилт хийж тогтоосон байна. (UNICEF, 2006a). Мөн үүний хамт, Монголын Засгийн газар Монголын боловсролын системийг олон улсын стандартад хүргэхийн тулд хуучин социалист ситемийн үед байсан 10 жилийн боловсролоос 11 жилийн боловсролын системд шилжих болсныг зарласан. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулаад, Монголын Засгийн газар сургуулийн сурагчдын элсэлт болон хамрагдалтыг бууруулахгүй хэвээр хадагалахын тулд сургуулийн хоол хөтөлбөрийг зөв зүйтэй алхам хэмээн хэрэгжүүлсэн. (Ministry of Education, 2006).

Сургуулийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах гурван үе шатанд хуваан үзэж болох юм. Үүнд туршилтын шат 2002 оноос, сургуулийн өглөөний цай хөтөлбөр 2006-2007, сургуулийн үдийн хоол 2008-аас өнөөг хүртэл. Өнөөгийн байдлаар 6-12 насны 275,000 сургуулийн сурагчид сургуулийн үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна (Ministry of Education, 2008).

Сургуулийн үдийн цай хөтөлбөрт нөлөөлж буй Монголын онцлогууд

Үдийн цай хөтөлбөр нэг талаараа нутагшмал, нөгөө талаараа нилээдгүй хэдэн жил энэхүү хөтөлбөр Монголд хэрэгжсэн тул өөрсдөө хөтөлбөрийнхөө талаар магтан сайшаах эсхүл болохгүй бүх шалтгааныг нь тоочихыг хойш тавьж, гадны экспертүүд юу гэж үзсэнийг сонирхуулья.

Хамгийн түрүүнд тэдний ярьсан шалтгаан нь газарзүйн байрлал. Монгол улс 2.7 сая хүн амтай, газар нутгийн хэмжээ нь маш том (1.6 сая хавтгай дөрвөлжин км), далайд гарцгүй Азийн улс. Газар нутгийн хэмжээг тоймлон авч үзэхэд Их Британи, Франц, Герман Италийг нийлүүлсэнтэй эн тэнцэхүйц, Японоос дөрөв дахин том, Азид газар нутгийнхаа хэмжээгээр 5-рт ордог улс юм. (Goyal, 1999). Газар зүйн байрлалынхаа хувьд, Монгол улс нь далайд гарцгүй тул хүнсний ихэнх хэсгийг хойд хөрш болох Орос улс, өмнөд хөрш болох Хятад улсаас оруулж ирж хэрэглэдэг. Хуучин социалист тогтолцооны үед Монголчууд газар тариалан эрхэлж өөрийн дотоодын хүнсний хэрэгцээгээ хангачихдаг түүгээр ч үл барам бусад социалист орнуудад экспортолдаг байсан олон баримт байдаг. Нийт Монголын газар нутгийн 80 хувь нь газар тариалан эрхлэхэд боломжтой ч, өнөөдөр зөвхөн 1.6 хувийг нь л газар тариалан, хүнсний зориулалтаар ашиглаж байгаа юм. (Goyal, 1999). Эндээс үзэхэд өнөөгийн сургуулийн үдийн цай хөтөлбөрийн боловсруулалт хийгдээгүй бүтээгдэхүүний нилээдгүй хэсэг нь гаднаас орж ирж байгаа бүтээгдэхүүнээс хамааралтай нь харагдаж байгаа юм.

Дараагийн нэг шалтгаан нь Монголын улс төр, эдийн засаг. Монгол улс сүүлийн 20 жилд л чөлөөт зах зээлийн эдийн засаг бүхий хөгжлийн замыг сонгон авч хөгжиж байна. Түүнээс өмнө бараг 70 жил Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, коммунист улс байсан. Харин 1990 оноос Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах эдийн засагт шилжин орсон. Энэ үеэс ажилгүйдэл бий болсон. Ажилгүйдэл буй болсноор ядуурал, салалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд олон гэр бүлүүдийг тойроогүй (Goyal, 1999). Дээрх нийгэм-эдийн засгийн өөрчлөлтүүд хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлсөн. Олон хүчин зүйлийн түүвэр судалгаагаар (MICS) судалгаагаар эрдэс тэжээлийн дутал 5-аас доош насны хүүхдүүдэд их байгааг тогтоосон. Тухайлбал: 5-аас доош насны хүүхдийн 6.3 хувь нь тураалтай, 20.9 хувь нь өсөлт хоцролттой, 2.2 хувь нь туранхай байсан байна. (UNICEF, 2006a). Харин 7-11 насны хүүхдүүдийн хувьд эрдэс тэжээлийн дутмаг байдал ажиглагдсан тухайлбал, витамин-А, В, Д болон кальцийн дутал нилээдгүй байгааг тогтоосон байна. (UNICEF, 2006a).

Дээрх дүгнэлтүүдээс болон Монголд хийгдсэн UNICEF-ийн тусламжтайгаар хийгдсэн хэд хэдэн судалгаагаар нь дээрх дүгнэлтийг баталсан байдаг. Дэлхийн бусад улс орнуудтай адил Монгол улс 5-аас доош насны хүүхдийнхээ тураал, өсөлт хоцролтыг багасгахад анхаарах нь тулгамдсан асуудал харин, Сургуулийн насны хүүхдийн хоол тэжээлийн асуудал нь шаардлагатай бол хүүхдийн эрдэс тэжээлийн дутлыг нөхөхөд чиглэгдэх нь зөв гарц гэж үзэхээр байна. Ингээд Монгол улсад Үдийн цай хөтөлбөр хэрэгжих зорилго зорилтыг авч үзье.

Үдийн цай хөтөлбөрийн зорилго, ач холбогдол, дүгнэлт

Сургуульд хамрагдалтыг дээшлүүлэх болон хоол тэжээлийн дутлыг нөхөх гэсэн зорилгыг агуулсан.

Сургуулийн хоол хөтөлбөр нь хамрах хүрээний хувьд маш өргөн. Монголын хүн амын 10 хувь нь хамрагдаж байгаа том хөтөлбөр хэдий ч үүний ач холбогдол, үр нөлөө нь ямар байгааг үнэлсэн үнэлгээ өнөөг хүртэл бүрэн утгаараа, тухайлбал ямар эрдэс тэжээлийг яаж нөхөж чадаж байгааг, хэрхэн үнэлж байгаа нь тодорхойгүй байна. Сургуулийн хоол хөтөлбөрийг судалсан олон судалгаанд эцэг эхчүүд зарим багш нарын зүгээс ч ач холбогдолтой эсэхэд эргэлзсэн байдаг. Мөн сургуулийн хоол хөтөлбөр нь өмнөө тавьсан зорилго болох сургуулийн хүүхдийг эрдэс тэжээлийн дутлыг хоолоор дамжуулан нөхөн сайжруулах, сургуульд завсардалтыг багасгах гэсэн үндсэн зорилго нь ч өчүүхэн төдий эерэг өөрчлөлтөд хүрсэн гэж үзэхээр байна (Oyuntsetseg, 2011).

Дүгнэлт: Үдийн хоол цай хөтөлбөр анхнаасаа л ядуу дорой иргэддээ чиглэсэн байдлаар анх хэрэгжсэн, Дэлхийн 2-р дайны дараагаар энэхүү хөтөлбөр нь улам өргөжсөн байдаг. Дэлхийн улс орнуудад 5-аас доош насны хүүхдүүдэд анхаарах, ялангуяа 0-24 сар хүртэлх хүүхдийн эрүүл мэндийг хоол тэжээлээр дамжуулан нөхөн сэргээх нь хамгийн үр дүн өндөртэй гэдэг нь батлагдаад байгаа.

Харин улс орнууд сургуулийн хоол хөтөлбөрийг боловсролоо дэмжих, сургуульд татах хүч байдлаар зохион байгуулахад ач холбогдолтой болохоос сургуулийн хүүхдийн эрдэс тэжээлийг хангаж байгаа туршлага болохуйц үр дүн бага байгааг тэмдэглэсэн байна. Өнөөгийн засгийн газар Үдийн цай хөтөлбөрөө, хоол хөтөлбөр болж цааш өргөжүүлэх тухай ярьж байна. Ингээд засаг төр нь хүмүүсээ халамжилдаг тогтолцоогоор явсаар л байх нь зөв үү эсвэл өөрийн орондоо тохирсон гарцыг хайсан нь зөв үү гэдэгт судлаач миний зүгээс дараа дараагийн өгүүлэлдээ өгүүлэх болно.

НОМ ЗҮЙ

- Bhutta, A. Z., Ahmed, T., Black, E. R., Cousens, S., Dewey, K., Giugliani, E., et al. (2008). What works? Interventions for maternal and child undernutrition and survival. *The Lancet*, 371(9610), 417-440.
- Black, R. E., Allen, L. H., Bhutta, Z. A., Caulfield, L. E., de Onis, M., Ezzati, M., et al. (2008). Maternal and child undernutrition: global and regional exposures and health consequences. *The Lancet*, 371(9608), 243-260.
- Bryce, J., Coitinho, D., Darnton-Hill, I., Pelletier, D., & Pinstrip-Andersen, P. (2008). Maternal and child undernutrition: effective action at national level. *The Lancet*, 371(9611), 510-526.
- Cueto, S., & Chinen, M. (2008). Educational impact of a school breakfast programme in rural Peru. *International Journal of Educational Development*, 28(2), 132-148.
- de Onis, M., Onyango, A. W., Borghi, E., Siyam, A., Nishida, C., & Siekmann, J. (2007). Development of a WHO growth reference for school-aged children and adolescents. *Bulletin Of The World Health Organization*, 85(9), 660-667.
- Du, X. Q., Zhu, K., Trube, A., Zhang, Q., Ma, G. S., Hu, X. Q., et al. (2004). School-milk intervention trial enhances growth and bone mineral accretion in Chinese girls aged 10-12 years in Beijing. *British Journal of Nutrition*, 92(1), 159-168.
- Gordan, W., Gunderson, . (2009). The National School Lunch Program Background and Development *United States Department of Agriculture (USDA), Food and Nutrition Service*
- Goyal, D. H. (1999). A Development Perspective on Mongolia. *Asian Survey*, 39(4), 633-655.
- Hall, A., Hanh, T. T. M., Farley, K., Quynh, T. P. N., & Valdivia, F. (2007). An evaluation of the impact of a school nutrition programme in Vietnam. *Public Health Nutrition*, 10(8), 819-826.
- Ministry of Education, C. a. S. o. M. (2006). *Master Plan to Develop Education of Mongolia in 2006-2015*
- Neumann, C. G., Bwibo, N. O., Murphy, S. P., Sigman, M., Whaley, S., Allen, L. H., et al. (2003). Animal source foods improve dietary quality, micronutrient status, growth and cognitive function in Kenyan school children: Background, study design and baseline findings. *Journal of Nutrition*, 133(11), 3941S-3949S.
- Oyuntsetseg, D (2011). Improving school attendance and supporting micronutrient intake: A critical review of the effectiveness of the Mongolian School Feeding Program. Master's thesis. Centre for Health & Society, Melbourne School of Population Health, Faculty of Medicine, Dentistry & Health Sciences, The University of Melbourne, Australia.
- Simeon, D. (1998). School feeding in Jamaica: a review of its evaluation. *Am J Clin Nutr*, 67(4), 790S-794.
- UNDP. (2008). *The Millennium Development Goals Report*. New York.
- UNICEF. (2006a). *Multiple Indicator Cluster Survey* Ulaanbaatar, Mongolia: National Statistical Office of Mongolia.
- UNICEF. (2006b). *School Feeding Joint Assessment Mission Report Mongolia*. Ulaanbaatar.
- UNICEF, & WFP. (2006). *School Feeding Joint Assessment Mission Report Mongolia*, Ulaanbaatar.